145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-20,220,000.00	-450,000.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-20,220,000.00</b>	<b>-450,000.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>54,096,304.57</b>	<b>115,469,034.80</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,152,146.67	88,248,451.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,248,451.24	203,717,486.04

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,136,704,900.00	1,955,314,553.96
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,965,826,900.00	1,905,323,053.96
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,952,129,300.00	1,889,489,453.96
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,391,290,700.00	1,373,527,377.84
210101	Үндсэн цалин	1,013,024,800.00	940,001,421.63
210102	Нэмэгдэл	248,253,100.00	325,341,518.92

Цэцэн-Уур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,307,000.00	5,024,999.40
210104	Урамшуулал	80,497,200.00	77,356,576.89
210105	Гэрээт ажлын хөлс	44,208,600.00	25,802,861.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	187,474,700.00	180,584,509.46
210201	Тэтгэврийн даатгал	132,065,100.00	130,875,188.06
210202	Тэтгэмжийн даатгал	13,852,400.00	12,710,609.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,082,000.00	10,130,571.03
210204	Ажилгүйдлийн даатгал	2,770,400.00	2,528,032.09
210205	Эрүүл мэндийн даатгал	27,704,800.00	24,340,109.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	119,433,600.00	107,988,171.66
210301	Гэрэл, цахилгаан	22,731,500.00	13,259,643.74
210302	Түлш, халаалт	93,656,700.00	93,576,984.00
210303	Цэвэр, бохир ус	3,045,400.00	1,151,543.92
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	65,317,400.00	59,456,636.00
210401	Бичиг хэрэг	7,049,500.00	7,010,720.00
210402	Тээвэр, шатахуун	45,586,200.00	41,443,542.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,965,700.00	6,110,700.00
210404	Ном, хэвлэл	1,622,200.00	1,539,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	563,700.00	563,224.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,530,100.00	2,789,450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	72,040,400.00	63,473,489.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,845,500.00	25,733,789.00
210502	Хоол, хүнс	41,126,600.00	34,149,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,068,300.00	3,590,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,736,100.00	7,297,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	715,400.00	715,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	296,200.00	296,200.00
210604	Урсгал засвар	6,724,500.00	6,286,150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,632,200.00	3,480,000.00
210702	Дотоод албан томилолт	6,632,200.00	3,480,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,215,100.00	20,108,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,475,900.00	17,469,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,911,700.00	1,782,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	124,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	120,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	14,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	100,000.00
210807	Газрын төлбөр	188,300.00	26,816.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62,400.00	30,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450,000.00	440,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,989,100.00	73,573,030.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,405,700.00	59,132,630.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,583,400.00	14,440,400.00

Цэцэн-Уур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,697,600.00	15,833,600.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,697,600.00	15,833,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,440,600.00	13,410,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	257,000.00	2,423,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>70,878,000.00</b>	<b>49,541,500.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	70,878,000.00	49,541,500.00
223001	Бусад хөрөнгө	70,878,000.00	49,541,500.00
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100,000,000.00	450,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000,000.00	450,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,050,794,100. 00	2,051,414,629. 96
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,326,295,000. 00	1,310,570,041. 56
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,326,295,000. 00	1,310,570,041. 56
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	613,418,700.00	637,068,388.40
132001	Орон нутгийн төсвөөс	555,625,800.00	579,318,011.40
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	57,792,900.00	57,750,377.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	17,109,100.00	15,435,552.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,109,100.00	15,435,552.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	93,971,300.00	88,340,648.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,971,300.00	88,340,648.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>176,494,157.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>166,654,157.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	126,012,314.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	18,713,843.00
210101	Үндсэн цалин	18,713,843.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,806,908.00
210401	Бичиг хэрэг	151,658.00
210402	Тээвэр, шатахуун	6,027,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,628,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	41,716,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,590,600.00

**Цэцэн-Уур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	3,125,800.00
2107	Томиллолт, зочны зардал	53,000.00
210702	Дотоод албан томиллолт	53,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,104,818.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,104,818.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,617,345.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,669,845.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,947,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,553,138.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,138.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,088,705.18
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	8,088,705.18
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,840,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	9,840,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,840,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>176,496,614.18</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	176,496,614.18
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,686,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,809,714.18

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 24-ны 1/36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэх
- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлэх
- Хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй сум болох
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах
- Нийгмийн амар тайван байдлыг хангах
- Эрсдэлгүй, өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйг хөгжүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 2,889.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 43.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 32.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 203.7 сая төгрөг болж өмнөх оноос 115.5 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 93.9 сая төгрөг нь СХС-ийн, 21.3 сая төгрөг нь ОНХС-ийн, 88.5 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

#### Авлага

Авлага дансны үлдэгдэл 210.2 сая төгрөг болж өмнөх оноос 1.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд үүссэн авлага, сум хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЗДТГ	121,179.42	1,468,656.12
ИТХ	-	192,190.27
ЭМТ	795,941.00	71,843,796.20
Сургууль	1,012,581.67	6,816,878.45
Цэцэрлэг	259,866.01	3,151,778.54
Соёлын төв	1,429,347.93	11,470.59
СХС	205,343,511.00	126,728,645.48
ДҮН	<b>208,962,427.03</b>	<b>210,213,415.65</b>

Илрүүлэлт: ТШЗ-ын аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 13.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

#### Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 150.2 сая төгрөг болж өмнөх оноос 3.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3945.3 сая төгрөг болж өмнөх оноос 166.2 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

#### Өглөг

Өглөгийн дүн 49.7 сая төгрөг болж өмнөх оноос 42.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь эрүүл мэндийн төвд ковид цар тахалтай холбоотой бий болсон байна.

#### Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 4,459.8 сая төгрөг болж өмнөх оноос 88.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 1,877.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 261.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,139.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт нэмж тодотгол хийсэнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,139.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,968.1 сая төгрөгийг урсгал зардалд, 70.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 100.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,326.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 555.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 17.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 57.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 93.9 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 88.2 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,332.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 596.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 15.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 57.8 сая төгрөг, нийт 2,002.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 45.5 сая төгрөг илүү байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 88.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 5.3 сая төгрөгөөр тасарсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байна гэж үзлээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,955.3 сая төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 17.5 сая төгрөгийг сумын төсөвт, 28.2 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 92.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 83.8 сая, нийт 176.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 158.5 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 9.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 129 мэдээллээс 127 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Цэцэн-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 2 заалт зөвлөмж өгсөн.

##### 4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1 Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал сумын тамгын газрын дарга нь өөрийн хувийн дансандаа мөнгө авч үндсэн хөрөнгө болон бараа материал бэлтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах

#### 2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын засаг дарга нь ТШЗ нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлыг үнэлж дүгнээгүй олгосон 1,0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2021 оны А/35/ А/10/9 дугаар хамтарсан тушаалын 3 дахь заалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч нарт ур чадварын нэмэгдэл өгөхдөө гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр бус, ур чадвар олгох шалгуураар үнэлж олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	11	62.6	1	17.5	5	10.4	3	26.8	2	7.9
2	Эрүүл мэндийн төв	6	293.5	2	21.5	1	13.2			3	258.8
3	Хүүхдийн цэцэрлэг	5	49.6	1	2.6					4	47.0
4	Ерөнхий боловсролын сургууль	6	85.3	2	70.5			3	8.0	1	6.8
5	Соёлын төв	3	4.9	1	2.6					2	2.3
6	ОНХС	2	17.0							2	17.0
7	Төвлөрүүлэн захирагч	2	15.5							2	15.5
<b>Дүн</b>		<b>35</b>	<b>528.5</b>	<b>7</b>	<b>114.7</b>	<b>6</b>	<b>23.6</b>	<b>6</b>	<b>34.8</b>	<b>16</b>	<b>355.4</b>

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР

Б.ЖАЛБАА

**ХЯНАСАН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

